

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 11  
ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХАМТАРСАН  
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

| <b>№</b>  | <b>Баримтын агуулга</b>   | <b>Хуудас</b> |
|-----------|---|---------------|
| <b>1.</b> | <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>   | 1-23          |
| <b>2.</b> | Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл  | 24-105        |
|           | 1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, <b>анхны хэлэлцүүлэг</b> , үргэлжилнэ/ | 26-74         |
|           | 2. Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, <b>анхны хэлэлцүүлэг</b> /                         | 74-105        |

### ***Хураангуй тэмдэглэл***

***Хоёр.Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын

газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга Д.Ганзориг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Л.Мөнхчимэг, гэрээт ажилтан Б.Галсанбат, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны ахлах референт Д.Ядамжав нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийтийн мэдээллийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Төслийн 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 23, 24, 25, 26, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 36, 38, 39 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Алтанхуяг, Д.Ганбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар” гэснийг “нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг, Н.Алтанхуяг нар төслийн гарчгийн “Нийтийн мэдээллийн тухай” гэснийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” гэж өөрчлөх гэсэн санал гаргав.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Алтанхуяг, С.Бямбацогт нарын гаргасан саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг, Н.Алтанхуяг нар цөөнх болов.

**С.Бямбацогт:** 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “цахим баримт бичиг, нийтийн”, “дамжуулах,” гэснийг, 4.1.5 дахь заалтын “хүн, эсхүл техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар” гэснийг, 4.1.11 дэх заалтын “цахим” гэснийг болон 4.1.9, 4.1.10 дахь заалтыг тус тус хасч, 4.1.1 дэх заалтын “программ” гэсний дараа “хангамж,” гэж нэмж, 4.1.2 дахь заалтын “суваг, техник хэрэгсэл болон программ хангамжийн” гэснийг “программ хангамж болон техник хэрэгслийн” гэж, 4.1.3 дахь заалтын “4.1.5-д заасан этгээд болон хуулийн этгээдийн” гэснийг “4.1.6-д заасан хүн болон тухайн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан” гэсний өмнө “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “бөгөөд төрийн нууцад үл хамаарах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9 дэх заалтын “үйл ажиллагааны чиглэлээрх салбарын нэгтгэн боловсруулсан” гэснийг “салбарын үйл ажиллагааны” гэж, өөрчилж, 8.6.20 дахь заалтын “мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн,” гэсний дараа “, гэрээний хэрэгжилт” гэж, 8.7 дахь хэсгийн “энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Улсын дээд шүүх,” гэсний дараа “энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц,” гэж тус тус нэмж, 8.14 дэх хэсгийн “цахим хуудас хариуцсан ажилтан” гэснийг хасч, 8.6.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.6.18 дахь заалт болгох:

“8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтын “мэдээлэл авагчийн нэр” гэснийг “мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр” гэж, 9.6.8 дахь заалтын “зөвшөөрлөө цуцлах нөхцөл” гэснийг “зөвшөөрлөө цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчилж, 9.6.4, 9.17.2 дахь заалтын “агуулга,” гэснийг болон 9.2.4, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар,

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг, 18.14 дэх хэсгийн “цахим хэлбэрээр” гэснийг тус тус хасч, 18.16 дахь хэсгийн “гэрээний загвар,” гэсний дараа “зардал тооцох аргачлал,” гэж нэмж, 18.14, 18.15 дахь хэсгийн “үндсэн систем” гэснийг “үндсэн болон дэмжих систем” гэж, 18.12 дахь хэсгийн “үндсэн системд холбогдсон мэдээллийн сангаас” гэснийг “үндсэн системээр дамжуулан” гэж тус тус өөрчилж, 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Энэ хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем нь нийтийн мэдээллийн системд хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 10 |
| Татгалзсан: | 6  |
| Бүгд:       | 16 |

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын бичгээр гаргасан саналд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 22.1-д заасан “нийтийн мэдээллийн” гэснийг “үндсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 9  |
| Татгалзсан: | 7  |
| Бүгд:       | 16 |

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасч, 24.4 дэх хэсгийн “нэгдсэн системээс” гэснийг “нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 10 |
| Татгалзсан: | 6  |
| Бүгд:       | 16 |

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 9  |
| Татгалзсан: | 7  |
| Бүгд:       | 16 |

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “албан харилцаанд” гэснийг “хуульд заасан чиг үүргийн хүрээнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “33.1.15-д” гэснийг “33.1.4, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16, 33.1.18-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.5.3 дахь заалтын “түүхчилсэн бичлэг /лог/ үүсгэх” гэснийг “үйлдлийн бүртгэл үүсгэх” гэж өөрчилж, 34.5.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Байнгын хорооны дарга С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд” гэснийг “нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд” гэж өөрчилж, 35.1.8 дахь заалтын “өөрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг” гэсний дараа “цахим хэлбэрээр болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ч.Ундрам нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Байнгын хорооны дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө нийтийн мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд энэ хуульд заасан шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.



19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “мэдээллийн системийн тусламжтайгаар” гэснийг “мэдээллийн системийг ашиглан” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын “харилцах утас” гэснийг “харилцах утасны дугаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.10 дахь заалтын “зохион явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 8.4.14 дэх заалтын “олон улсын байгууллагаас авах зээл” гэснийг “олон улсын байгууллагаас авсан зээл” гэж, 9.15 дахь хэсгийн “баталгаа” гэснийг “баталгаажуулалт” гэж, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн “үйл ажиллагааны болон” гэснийг “үйл ажиллагаа,” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.5 дахь заалтын “нэвтрэлт хийгдсэн” гэснийг “нэвтэрсэн” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “мэдээлэл хариуцагч,” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийн “ил тод, нээлттэй” гэсний өмнө “байнга” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “соёлын хосгүй” гэсний дараа “үнэт” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “тухайлсан” гэж тус тус нэмэх.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.14 дэх заалтыг доор дурдсанаар 8.6.14, 8.6.15 дахь заалт болгох:

“8.6.14.шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;

8.6.15.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйл, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

**С.Бямбацогт:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**1 дүгээр зүйл.**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.9-д заасныг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “мөрдөж болно” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “тоон гарын үсгээр” гэснийг “цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” болгож өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “15.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ““хязгаарлалттай мэдээллийг” гэсний өмнө “Албаны нууцаас бусад”” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 4 цаг 15 минут үргэлжилж, 29 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 72.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 45 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.УЧРАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ

АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

### ***Дэлгэрэнгүй тэмдэглэл***

**Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Учрал танилцуулна.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засгийн газраас 2021.05.19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Их Хурлын даргын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 54 дүгээр захирамжаар байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Учрал, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Анужин, Бат-Амгалан, Доржханд, Мөнхбаатар, Саранчимэг, Сүхбаатар, Цогтбаатар нарын гишүүд орж ажиллалаа. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг 43 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг өнгөрсөн хугацаанд 16 удаа, ажлын хэсэг 2 удаа хуралдсан.

Ажлын хэсгийн гишүүд Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, Үндэсний дата төвийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан. Ажлын хэсэг хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцүүлэх, хуулийн төслийн уялдаа холбоог хангах, нэр томьёо, хэл найруулга, агуулга, бүтцийн шинжтэй зарчмын

зөрүүтэй саналын томьёоллуудыг бэлтгэн ажлын хэсгийн хуралдаанаар нэгбүрчлэн хэлэлцэж, олонхын саналаар дэмжигдсэн дараах саналуудыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1-т, нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх талаар хуулийн төслийн зарчимд нэмж тусгахаар,

2-т, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлаас гадна гэрээний хэрэгжилтийг байнга нээлттэй, ил тод байлгахаар,

3-т, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргааныг хянан шийдвэрлэсэн ажиллагааны үр дүн мэдээг Үндсэн хуулийн цэц хариуцаж, байнга ил тод, нээлттэй байлгахаар,

4-т, мэдээлэл хариуцагчаас бусад хуулийн этгээд нь иргэдээ үйлчилгээ үзүүлэхдээ үндсэн болон дэмжих системийг ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд Засгийн газраас баталсан аргачлалын дагуу зардлыг төлөхөөр,

5-д, Засгийн газрын бүтцийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болгох гэх мэт өөрчлөлтүүдийг зарчмын зөрүүтэй саналын томьёололд тусгалаа.

Дээр дурдсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагчид баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг, түрүүнийх хэвээрээ тийм ээ. Нэмэгдсэн хасагдсан хүн байхгүй ээ. Түрүүн танилцуулагдсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ганбат гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Үндсэн хуулийн 16.17-д Монгол Улсын иргэн төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэдгийг баталгаажуулсан. Энэ бол Монгол Улсын иргэний мэдээлэл олж авах, дээр нь төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод байхыг Үндсэн хуулиар хамгаалсан чухал заалт. Гэтэл 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууц гэдгээр албаны нууц

гэдэг нэрээр төрийн тусгай мэдээллүүдийг төрийн байгууллагууд нууцлах, сэтгүүлчид болон олон нийтээс далдлах ийм зохицуулалт хийж ухралт үзүүлсэн.

Харин энэ удаагийн Засгийн газраас өргөн барьж байгаа энэ Нийтийн мэдээллийн тухай хуульд мэдээлэл хариуцагчаас олон нийтэд нээлттэй ил тод байх мэдээллийн төрөл зүйлийг нэмэгдүүлсэн, мөн хууль ил тод нээлттэй байхаар заасан. Эсхүл төрийн нууцад үл хамаарах мэдээллийг албаны нууцад оруулахгүй гэж оруулж ирж байгаа нь ихээхэн дэвшилттэй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн 16.17 руугаа ойртуулсан сайшаалтай хууль болж байна.

Гэхдээ хуулийн зорилго болон нэр дээр бас тодорхой асуулт байна. Ер нь бол хууль маань анх мэдээллийн цахим дэд бүтцийн тухай хууль гэж явж байснаа мэдээллийн ил тод байдлын хуультай хамтатгаад явчих шиг болсон. Одоо ингээд хуулийн зүйл, заалтуудаа харахаар ер нь мэдээлэл олж авах эрхийг хангах гээд байгаа юм уу эсвэл төрийн мэдээллийн үйл ажиллагаанд тавих менежмент хийх гээд байгаа юм уу. Төрийн мэдээллээ зохицуулах гээд байгаа юм уу гэдэг нь бас ойлгомжгүй байгаад байна.

Тэгээд миний хувьд энэ хуулийн нэр дээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж өөрчлөх ийм саналтай байгаад байна. Нийтийн мэдээллийн хууль биш Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. Ингэж байж энэ хуулийн зорилго юм нь илүү хангагдахаар байгаад байна. Ийм санал гаргаж байна.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Учрал гишүүн.

**Н.Учрал:** Нэр томъёоны хувьд бид ажлын хэсэг дээр ярилцсан. Тэгээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн хууль гэдэг энэ нэр томъёогоороо явах нь зохимжтой юм байна гэж үзсэн. Яагаад вэ гэхээр хатуу дэд бүтэц, зөөлөн дэд бүтэц гэж юм байгаа юм. Жишээ нь энэ хатуу дэд бүтэц дээр нь суурилж мэдээллийн ил тод байдлыг хангах, тэр мэдээллийг хаалттай, нээлттэй, хязгаартай байдлаар нь ангилах ажлыг зохион байгуулахгүй бол болохгүй юм байна. Жишээ нь Нийтийн мэдээллийн хуулийг хэрэгжүүлэхэд хатуу дэд бүтэц маш чухал байгаа. Тийм учраас Нийтийн мэдээллийн хууль дээрээ бол бид нар холбогдох зарим хуульгүй байсан төрийн үндсэн системийг хэрэгжүүлж байгаа юм. Дэмжих системийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг хуульчилж, эрх үүргийг нь тодорхой болгож өгснөөрөө цаашдаа энэ мэдээ мэдээллүүдийг хамгаалах, хадгалах, ангилах, боловсруулах гээд бүх түвшинд энэ хууль маш хэрэгцээтэй. Тийм учраас Нийтийн мэдээллийн хууль буюу паблик информейшн гэдэг энэ гаднын нэршлээр нь явах нь зохимжтой байна гэж үзсэн. Энэ бол зөвхөн цахим харилцаатай холбоотой биш дээрээс нь зөвхөн мэдээллийг ил тод болгох гэж байгаадаа биш учраас энэ Нийтийн мэдээллийн хууль гэдэг нэршил нь зохимжтой гэж үзэж байгаа.

Мөнхцэцэг гишүүний хувьд зарчмын зөрүүтэй саналаа бичгээр гаргаад танилцуулж болох байх аа.

**С.Бямбацогт:** Нэмээд хариулах уу. Сайнзориг.

**П.Сайнзориг:** Мөнхцэцэг гишүүний асуултад нэмж хариулъя. Учрал гишүүн гол санааг нь хэллээ. Гэхдээ энэ дээр өнөөдөр өмнөх үйлчилж байсан хууль маань Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль гэж байгаа. Энэ

болохоор зөвхөн төрийн байгууллагад хамаатай байсан. Тэгэхээр энэ удаа төрийн байгууллага дээр нэмэх нь төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компани, олон нийтийн өмчтэй Олон нийтийн радио телевиз нэмэх нь улс төрийн нам гэдэг энэ нийтийн эрх зүйн субъектүүдийг оруулж ирсэн учраас энд байгаа мэдээллүүдийг зөвхөн төрийн байгууллагын ил тод байдал гэж бас ярьж болохгүй юм аа. Тэгэхээр энэ утгаараа бид нар Нийтийн мэдээллийн тухай гэж нэрлэсэн байгаа. Ер нь зүгээр яах вэ боловсруулах явцад ч гэсэн бид хэд ярьсан. Аль болохоор хуулийн нэр бас товч тодорхой байя. Зорилт дээрээ энэ таны ярьж байгаа үйл ажиллагаануудыг илүү их тодруулж өгч байгаа.

Тэгэхээр төрийн одоо юу гэдэг юм мэдэх эрх тийм ээ, мэдэх эрхээ хангуулах, мэдээлэл авах эрхээ хангуулах гэдэг асуудлын замд хүртээмж, шуурхай байдлын асуудал байгаа. Энэ шуурхай байдал, хүртээмжийн асуудлыг өнөөдөр орчин үеийн технологийн үед технологи ашиглаж буюу цахим байдлаар шийдэх энэ гарцыг энэ хууль илэрхийлж уяж өгч байгаа гэсэн үг.

Тэгэхээр тэс 2 ондоо зүйл биш энэ төрд байгаа буюу нийтийн эрх зүйн субъектүүдэд байгаа мэдээллийг яаж амар хялбараар тухайн тэр хэрэгцээтэй хүн, хуулийн этгээд нь хүрэх вэ гэдэг асуудал нь өөрөө эргээд нийтийн мэдээллийн дэд бүтэцтэйгээ уялдаж байгаа. Үүгээр авсан мэдээлэл нь албан ёсны эх сурвалж болно. Албан ёсны бичиг баримт болно. Энэ албан ёсны бичиг баримт дээрээ маргаан ч гэдэг юм уу аливаа юмны шүүх дээр нотлох баримт болно. Энэ утгаараа бид нар нөгөө бүх юмны уялдаагаас нь хангаж бас энэ хэд хэдэн харилцаануудыг нэгтгэж, энэ тэгэхдээ цогц байдлаараа шийдэгдэх энэ хувилбараар ингэж боловсруулагдсан гэдэг зүйлийг танд хэлье.

**С.Бямбацогт:** Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхцэцэг:** Хуулийн зорилго бол төрийн үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах гэдэг утгаараа энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гээд явчихвал ерөөсөө буруудах зүйлгүй буюу илүү тэр олон улсын стандарт руугаа бид нар ойртох гээд байгаа юм биш үү гэсэн утгаар энэ саналыг оруулаад байгаа юм л даа. Үүнийг тэгээд ажлын хэсэг дээрээ та хэд яриад болохгүй бол зарчмын зөрүүтэй санал оруулъя.

**С.Бямбацогт:** Тийм, гишүүд санал гаргаж болно шүү дээ. Мөнхцэцэг гишүүн ээ. Зарчмын зөрүүтэй санал гаргаад бичгээр хураалгаж болно. Нээлттэй. Тийм болохоор саяын саналаа та бичээд өгч болно.

Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

**Н.Алтанхуяг:** Ер нь энэ Мөнхцэцэг гишүүний хэлж байгаа шиг л нэрлэмээр байгаа юм л даа. Огт ойлгомжгүй нэр томьёо. Бид нарт огт ойлгомжгүй байгаа юм чинь иргэнд бол бүр ойлгомжгүй болж байгаа шүү дээ. Нийтийн мэдээллийн тухай гээд. Тэгэхээр энэ Үндсэн хуулиар олгогдсон эрх чинь бол иргэн бол мэдээлэл авах эрхтэй. Тэр Үндсэн хуулийн гол санааг л уг нь хуульчилж л байгаа юм л даа. Ямар хэлбэрээр ямар дэд бүтцээр авах гэдэг бол дараагийн л асуудал байгаа юм. Тэгэхдээ манай энэ оруулж ирсэн нөхөд ингээд зүтгээд л байгаа юм. Одоо тэгээд болохгүй бол одоо Мөнхцэцэг гишүүнтэйгээ нийлдэг л байх даа. Ер нь наадах чинь иргэнд ойлгомжтой байх ёстой байгаа юм л даа. Бид нар их олон дэд бүтэц яриад өөр тийшээ.

2 дугаарт нь бол дэвшил гарч байгаа, гарч байгаа. Ер нь бол энэ их олон нуучихсан байсан дарганцруудын үзэмжээр ингээд албаны нууц гээд биччихдэг байсан юмнуудаас тодорхой хэмжээнийх нь гарч байгаа. Ер нь тэгэхдээ 2016 онд агуу том ухралт хийсэн юм шүү дээ. Өмнө нь ингээд байсан хуулиар бол нууц гэдэгт багахан, цөөхөн отооны хамаардаг байсан чинь 2016 онд хууль гарснаас хойш бол дарга бүхэн нууцтай болсон. Тэр байтугай төсвийн мөнгөөр барьсан хэдэн төгрөгөөр барьсныг хүртэл нууцалдаг ийм л болчихсон. Тэгэхээр энэ бол засаж сайжруулах гэж байгааг нь би дэмжиж байгаа. Ажлын хэсэгт орж ажилласан.

Ташрамд хэлэхэд ажлын хэсэгт ороод одоо та нарын санал хураах гэж байгаа бүх зүйл, заалтаар нь би өчигдөр бас суугаад ажиллачихсан учраас өнөөдөр би бүгд дээр нь дэмжинэ. Гэхдээ би өөрөө байхгүйгээр дэмжиж байна. Болно шүү дээ. Би одоо өчигдөр яасан бүх юмаа ингээд дахиад л ингээд байхад жоохон хэцүү байна аа. Та нар маань ойлгоорой. Тийм ээ. Би хувийнх дээр нь байгаагүй учраас би тэр дээр хариуцлагатай нэмж ажиллая гэдгээ хэлчхээд байна. Ийм л юм байгаа юм. Тэгээд нэр дээрээ дахиад нэг анхаараадахаач. Яах вэ дэвшил гарч байгаа юм. Гэхдээ Монголын төр дандаа дэвшиж баймаар байна. Ухардаг араандаа хийгээд аймаар хол ухарсан байхгүй юу. Тэгээд энэ хооронд чинь энэ төрийн өмч хөрөнгө, элдвийн янзын юм дээр бол жинхэнэ хаалт бий болсон. Харин энэ хууль дээр гарч байгаа дэвшил чинь төрийнхөөс гадна тэр улс төрийн нам, тэр үндэсний радио телевиз, төрийн өмчийн компани, орон нутгийн. Эд нар бол сайн. Тэгэхдээ дахиад нэг хууль гаргаад энэ дотор байгаа юмыг чинь алга болгочих вий дээ. 5 зүйлийн 57 зүйл бол иргэдэд нээлттэй болж байгаа гэж би хэлж байгаа. Энэ рүү хуруу хумсаа хийчихгүй байхаар энэ хуулиараа хааж өгөөрэй л гэж хүсье. Баярлалаа.

Тэгээд би Бямбацогт даргад хэлчихлээ. Би өчигдөр бүгдийг нь нэгбүрчлэн орж ярьсан. Чадлынхаа хэмжээнд. Дутуу юм зөндөө байж магадгүй.

**С.Бямбацогт:** Дэгийн хуулиар чинь Алтанхуяг гишүүн ээ. Явчхаар сөрөг гарна. Картаа сугалахаар тасалсан болчихно тэгээд хэцүү л байна даа. Дэмжиж байгаагаа хэлсэн нь юу яаж болдоггүй шүү дээ. Та бас зөв ойлгоорой.

Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Энэ ийм л дээ. Нийтийн мэдээллийн тухай хууль. Энэ чухал хууль аа. Энэ мэдээллээр бол хүмүүс мэдээллийн дайн ч явуулдаг болчихсон. Мэдээллийн дайныг бүр эмх замбараагүй байдал, дайн ч болгож болдог болчихсон. Тухайлбал, Америкт бол алдаа гаргаад л сонин дээр бол дайн болж байна аа гээд биччихсэн. Гэтэл энэ чинь алдаа болчихжээ гэнгүүт, наадахыг чинь дайн болгоно оо гээд дараагийнхаа 2 дугаарыг өдөөн хатгасан юм гаргаа ингээд дайн болгочихсон байдаг байхгүй юу. Үүгээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр шүүх дээр цахим мэдээллийн сан, цаасан мэдээллийн сан гэж байна аа. Цахим мэдээллийн сан нь хоосон болчихоод цаасанд мэдээллийн сан дээр болохоор би намуудын тухай ярих гэж байна. Энэ бас улс төрийн нам гээд ороод ирчихсэн байна л даа. Улсын бүртгэлийн гэрчилгээ нь байдаг. Тамга нь байдаг. Ингээд явж байтал гэнэтхэн эргээд янз янзын мэдээлэл өгөөд байдаг. Нөгөө хариуцсан албан тушаалтнууд нь. Тэгээд бас намын хурлууд болж байна аа. Намын хурал болохдоо яаж болж байна вэ гэхээр хууль хамаагүй ээ. Хуулийг дагахгүй байж болно оо. Шүүх хамаа байхгүй ээ. Хэдэн хүн цуглуулаад л бүлэг нийтээрээ нийлчхээд ингээд яавал бид нар бараг өвлийн ордныг эзэлдэг, нөгөө большевикууд шиг л юм яриад байгаа байхгүй юу. Ийм байж болох юм уу үгүй юу. Тэр дээр тухайлбал одоо



хариуцлагатай ажил хийж байсан, экс Ерөнхийлөгч нар, Ерөнхий сайд нар бол хар машины программын хугацаа нь дууссан гэж байна. Нөгөө сонгууль явуулдаг. Гэтэл үүгээр юу хэлж байна гэхээр дараагийн эмх замбараагүй байдалд уриалан дуудаж байна уу ямар байна. Энэ мэдээллийг ашиглаад. Тэгээд манай Ерөнхий сайд байсан, бие дааж дэвшсэн нөхөр бол гараад ирэхдээ баахан хүний гарыг алгадаад нисдэг жордан шиг л юм орж ирж байгаа байхгүй юу. Ингээд тавилттай ийм жүжиг бэлдээд ингэж явуулаад хүмүүсийн толгой угаагаад улс орныг эмх замбараагүй байдалд оруулах мэдээллээр ийм юм байна аа.

Тухайлбал Засгийн газраас, ковидын үед гээд 3 дугаар тунгаа хийгээгүй хүмүүс 20 мянгаар шинжилгээ өгнө өө гээд. Ийм зүйл заалт байтал хүртэл үүнийг зөрчөөд л явуулна. Тэгээд дараа нь олон нийтийн сүлжээ энэ хэвлэл мэдээллээр яваад байгаа цахим болчхоор маш их хурдтай тардаг болж. Үүнийг яаж хязгаарлах юм, яах юм. Энэ талаар би юун дээр асууна шүү. Чуулган дээр. Тийм учраас холбогдох албан тушаалтнуудыг авчраарай. Миний энэ ярьж байгаа юмны талаар.

Тэгээд л эсрэг одоо олон нийтийн сүлжээгээр цахим сүлжээгээр бол, Увсынхан 1 нам аваадахжээ. Нөгөө Монгол Улсын тулгуур багана болсон. Тухайлбал хэдэн баядууд авчихжээ. Нөгөө эрх мэдэлтэй энээ тэрээ гээд шүүмжлэлд ороод эхэлж байгаа юм. Тэр шүүмжлэлд өтөөд байгаагийн 1 нь манай Алтанхуяг гишүүн, манай хуучин байсан, одоо байгаа Цогтгэрэл гишүүн, одоо өмнө нь байсан Дорлигжав, одоо Засгийн газарт. Байгаа Нямдорж сайд энэ тэр байгаа юм л даа. Энэ мэтчилэнгээр ахиад 7 сарын 1-нийг давтуулчихалгүйхэн шиг энэ мэдээллийнхээ хуулийг маш нарийн нягт хиймээр байгаа юм. Тийм. Энэ асуултдаа хариултыг нь авчихъя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр хэлэлцэж байгаа холбоотой асуудлаар асуултаа асуух ёстой. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авна уу гэсэн байгаа, асуултаа. Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчийг 1 дүгээр зүйлтэй холбогдож байгаа зүйлд нь хариулъя. Холбогдохгүй байгаа зүйл бол хариулагдахгүй.

Гишүүд маань холбоотой зүйлээр л асуух ёстой. Учрал гишүүн хариулъя.

**Н.Учрал:** 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт байсангүй. Гэхдээ 1 бас улс төржиж байгаа юм. Нийтийн мэдээллийн хууль гэнэ үү мэдээллийн ил тод байдлын хууль гэнэ үү. Ямар ч басан Засгийн газар бол тэр нууцаар хамгаалагдаад нууцлаад байгаа тодорхой мэдээллүүдээ нээлттэй болгоо гэдэг тийм дэвшилттэй хуулийг бол оруулж ирсэн. Энэ Их Хурал одоо батлах гэж байна аа. Тэгэхээр төрийн албаны болон албаны нууцын хууль чинь бол 2016 онд нөгөө хүний эрх, эрх чөлөө, мэдээллийн ил тод байдлыг ярьдаг Ардчилсан намын үед батлагдсан юм байна лээ. Би өчигдөр тэр жагсаал цуглаан хийх журмын хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн мэдүүлсэн чинь энэ 1994 оны хуулиасаа ухралт хийгээд 2015 онд нөгөө ардчилал, эрх, эрх чөлөө, жагсаал цуглааны тухай ярьдаг Ардчилсан нам өөрсдөө энэ хуулийг 2015 онд баталсан юм байна лээ. Тэгээд ер нь энэ талбай дээрх тэр хашаа хороог чинь ер нь Ардчилсан намын үед л бий болгосон юм байна лээ гээд үнэн зүйлийг бас хэлье. Тэгэхгүй бол бас ярьдаг шигээ байгаач ээ гэж олон хүмүүс шүүмжилж байгаа шүү дээ. Тийм учраас ардчилал, эрх, эрх чөлөө ярих гэж байгаа бол энэ ухралтуудыг бол 2012-2016 онд хийсэн юм байна лээ.

Тэгэхээр үүнийг засаж залруулахаар Засгийн газар оруулж ирж байгаа юм.

**С.Бямбацогт:** Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдъё. Хэдүүлээ улс төржихгүй тийм үү, асуудал дээрээ сайхан ажил хэрэгч төвлөрөөд хандъя аа. Өөр асуудал ярих аа больё оо.

1 дүгээр зүйлтэй холбогдуулж Ганбат гишүүн ээ, та асуултаа асуугаарай. Хэлэлцэж байгаа асуудлаас хальтраад явчих юм бол микрофон хаана шүү. Сануулъя танд. Одоо улс төржөөд яах юм бэ. Хуулиа явцгаая.

Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Би нийтийн мэдээллийн тухай маш ач холбогдолтой асуулт асуугаад байна л даа. Сайн анхааралтай сонсчихвол зүгээр байна. Би тухалбал тэр цахим мэдээлэл, цаана байгаа архив 2 зөрвөл яах юм бэ. Цахим мэдээлэл дээр тэр мэдээллээ тавихгүй байвал яах юм бэ гэсэн зүйл асууж байна.

Тухайлбал хэн нэгэн этгээд худал мэдээлэл гаргаад цахим орчинд тараагаад түүнээс нь болоод тухайлбал хар машин программын хугацаа дууссан байна аа гээд. Бүх юм хуулийнхаа дагуу явагдчихсан шүү дээ. Тэгэхгүй бол энэ нөгөө хууль ёсны легитим гэдэг чанарыг нь алдагдуулахаар юмыг одоо мэдээллээр ингээд тараагаад эхэлж байна аа. Энэ чинь улс орныг эмх замбараагүй байдалд хүргэчихвэл энэ хуулиараа хааж чадах юм уу. Ямар байгаа юм. Тэрийг л би асуугаад байгаа юм л даа. Одоо 2 сонгууль явчихлаа шүү дээ. Энэ хууль чинь үйлчилдэг, олон түмэнд хэрэгтэй. Ийм хууль болох ёстой. Тэгэхгүй бол нөгөө Ерөнхийлөгчийн сон ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** хэн хариулах вэ. Баасандорж дарга хариулъя. Цахим цаасан 2-ын аль нь хүчинтэй юм бэ гэсэн асуудал яригдаж байна. Буруу зөв мэдээлэл гаргах юм бол энэ хууль яаж зохицуулах юм бэ гэсэн асуудал яригдаж байна.

**Б.Баасандорж:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Цаасан баримт болон цахим баримттай холбоотой асууж байна. Хэрвээ цахим баримт маань цаасан эх нотлох баримттай зөрөх юм бол бид нар энэ асуудлыг зохицуулахаар Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. Энэ хуулийн өөрчлөлтөөр 38.3 дээр цахим баримт бичгийн хувь нь цаасан хувьтай адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд цаасан хувийг буюу эх нотлох баримт цаасан хувиа баримтална гээд Архив, албан хэрэг хөтлөлтийн хуульд хийж өгч байгаа.

**С.Бямбацогт:** Мэдээллийн хариуцлагатай холбоотой асуудлаар гүйцээгээд хариулчих, Баасандорж дарга.

**Б.Баасандорж:** мэдээлэл хариуцагчийн үүргийг энэ Нийтийн мэдээллийн тухай хуулиар зохицуулж өгч байгаа. Мэдээлэл хариуцагч одоо мэдээллийн эзний өмнө ямар үүрэг хүлээх юм. Мөн тэр тухайн байгууллагын тэр ажилтан ямар үүрэг хүлээх талаар зохицуулаад хэрвээ тогтоосон хугацаанд хуулийн дагуу мэдээлэл хариуцагч маань энэ үүргээ биелүүлэхгүй бол Зөрчлийн тухай хуулиар бид нар холбогдох хуулийг нь дагуулаад Зөрчлийн тухай хууль дээр хийж өгсөн байгаа.

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад 1 санал ажлын хэсгээс гаргасан байна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар” гэснийг “нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ганбат дарга аа, хуралдаа, санал хураалт.

Ирц хүрэхээ больчихлоо шүү дээ.

Гишүүдээ дуудна аа.

Тасалсан гишүүдээ бас дуудна аа. Давхар. Ирц аваад ир.

Эхний ээлжид өглөө ирсэн гишүүдээ танилцуулъя. Бямбацогт ирсэн, одоо сууж байна. Адьшаа гишүүн өглөө ирцдээ орсон, 10 цагаас хойш 2 цаг 30 минут алга болсон байна, картаа сугалаад. Алтанхуяг гишүүн танхимдаа хуралдаа оролцож байна. Амарсайхан гишүүн өглөө ирцэд орсон, бас 2 цаг 30 минут алга болсон байна. Хуралдаандаа ирнэ үү, дуудаж байна. Ганбат гишүүн хуралдаа сууц байгаад сая картаа сугалаад гараад явчихлаа. Дэлгэрсайхан гишүүн өвчтэй, Мөнх-Оргил гишүүн гадаад томилолттой. Мөнхбаатар гишүүн өглөө ирцэд орсон, одоо бас алга байна. Хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Мөнхцэцэг гишүүн хуралдаандаа оролцож сууж байна. Нямбаатар гишүүн хуралдаандаа оролцож байна. Пүрэвдорж гишүүн хуралдаандаа оролцож байна. Раднаасэд гишүүн хуралд сууж байсан, түрүүн байсан, хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна аа. Сандаг-Очир гишүүн сая ажлын хэсгийн хуралд чөлөө аваад гарсан байгаа. Сүхбаатар гишүүн хуралдаанд оролцож байна. Сэргэлэн гишүүн саяхан сууж байсан, хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Учрал гишүүн ажлын хэсгийн ахлагч байна. Цогтбаатар гишүүн яөлөө авсан, одоо ирэх хугацаа нь болсон, Цогтбаатар гишүүнийг хуралдаандаа ирэхийг урьж байна. Энх-Амгалан гишүүн түрүүн байсан, гараад явсан байна, хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Энхбаяр гишүүн гадаад томилолттой. Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн үндсэндээ ирц бол тасалсан гишүүн алга байна. Хуралдаанд ирцэд орсон мөртлөө ирээгүй гишүүд байна шүү. Одоо хуралд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүдээс Учрал гишүүн ирсэн байна. Амартүвшин гишүүн ирсэн байна. Саранчимэг гишүүн ирсэн байсан, картаа сугалаад гараад явсан байна. Хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Сэргэлэн гишүүн ирсэн байсан, хуралдаанд урьж байна. Батшугар гишүүн хуралдаандаа сууж байна. Идэрбат гишүүн гадаад томилолттой. Чинбүрэн гишүүн өвчтэй.

Бат-Амгалан гишүүн, Ганхуяг гишүүн, Ганибал гишүүн, Ундррам гишүүн, Доржханд гишүүн нар тасалсан байна аа. Өвчтэй гэж бүртгүүлдэггүй юм. Бичигтэй байдаг юм.

Тасалчхаад тэгээд өвчтэй гээд л утастаад хэлчихдэг. Тэгдэггүй юм.

Тасалсан гишүүд хуралдаандаа тасалсан байна шүү. Тийм.

Гишүүдийг танхимд урьж байна. Манай Хууль зүйн байнгын хорооны ажлын алба гишүүдээ дуудъя.

Дуудах гишүүдийг хэлж өгье. Адьшаа гишүүн, Амарсайхан гишүүн, Мөнхбаатар гишүүн, Раднаасэд гишүүн, Сэргэлэн гишүүн, Цогтбаатар гишүүн, Энх-Амгалан гишүүдийг.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүдээс Саранчимэг гишүүн өглөө ирцэд орсон байгаа. Амартүвшин гишүүн 2-ыг дуудъя.

Тасалсан гишүүдийг дахиж танилцуулна аа.

Бат-Амгалан гишүүн, Ганхуяг гишүүн, Ганибал гишүүн, Ундррам гишүүн, Доржханд гишүүн тасалсан байна.

Хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна аа. Бас.

Гишүүд ээ, хуралдаандаа орж ирэхийг урьж байна. Сая ирц сонссонтой холбоотой гишүүд бас ойрхон гарчих шиг боллоо. Ирц хүрсэн байна. Ундррам гишүүн хуралдаандаа хүрэлцэн ирсэн.

Сая сууж байсан Амартүвшин гишүүн, Нямбаатар гишүүн, Саранчимэг гишүүн, Сэргэлэн гишүүн. Өөр хэн хэн байна. Хуралдаандаа санал хураалт явуулъя.

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Бүртгэлийн санал хураалт.

Нямбаатар гишүүн, Раднаасэд гишүүн, Амартүвшин гишүүн, Сүхбаатар гишүүн, Саранчимэг гишүүн хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урья.

Бүртгэлийн санал хураалт.

Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар” гэснийг “нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 16 гишүүн оролцож, 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа.

Төслийн нэрийг өөрчлөх санал гаргасан байна.

Мөнхцэцэг, Алтанхуяг, Бямбацогт. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж нэрлэх. Нийтийн мэдээллийн тухай гэснийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж нэрлэх. Санал гаргасан Мөнхцэцэг, Алтанхуяг, Бямбацогт, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжигдсэнгүй энэ санал. Санал гаргасан гишүүд цөөнх. Би цөөнх боллоо шүү.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 10 саналаар санал бэлдсэн байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “цахим баримт бичиг, нийтийн”, “дамжуулах,” гэснийг, 4.1.5 дахь заалтын “хүн, эсхүл техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар” гэснийг, 4.1.11 дэх заалтын “цахим” гэснийг болон 4.1.9, 4.1.10 дахь заалтыг тус тус хасч, 4.1.1 дэх заалтын “программ” гэсний дараа “хангамж,” гэж нэмж, 4.1.2 дахь заалтын “суваг, техник хэрэгсэл болон программ хангамжийн” гэснийг “программ хангамж болон техник хэрэгслийн” гэж, 4.1.3 дахь заалтын “4.1.5-д заасан этгээд болон хуулийн этгээдийн” гэснийг “4.1.6-д заасан хүн болон тухайн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1 санал байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан” гэсний өмнө “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууж.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Нийтийн мэдээллийн тухай хууль бол уг чанартаа төрийн мэдээллийг ил тод болгох, иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хангаж байгаа дэвшилттэй хууль байгаа. Гэтэл яг энэ 7 дугаар зүйл дээр шинээр оруулж байгаа 7.1.6, 7.1 дээр байгаа хязгаарлалттай мэдээлэл гэдэг шинэ нэр томъёо

буюу шинэ энэ хуулийн зохицуулалт маань иргэдийн дунд мөн иргэний нийгмийн байгууллагуудын дунд ер нь хуульчдын дунд бас их асуудал, төөрөгдөл үүсгээд байна. Төрийн мэдээллийг хязгаарлалттай гэдэг нэрээр ангилаад тодорхой энэ мэдээллийг олж авах иргэн эсвэл сэтгүүлч байна уу. Энэ хүмүүс маань заавал зөвшөөрөл авахаар шаардаад байна. Энэ маань нөгөө төрийн албаны нууцын тухай хуулийн нууц гэдэгтэй чинь ерөөсөө зарчмын хувьд адилхан байгаад байна. Ер нь энэ хязгаарлалттай мэдээллийг эрж олж авах, хайх, үүнийг түгээхийн тулд заавал төрийн байгууллагаас зөвшөөрөл авч байгаа. Мэдээлэл хариуцагчаас. Энэ маань нэлээн тийм ухралт юм болов уу гэж хараад байна. Тэгээд энэ хуулийн үндсэн зорилготой ч нийцэхгүй байгаад байгаа. Хуулийн үндсэн зорилго бол төрийн мэдээллийг ил тод байлгах, нууцалбал зохих мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийн шалгуурын дагуу нууцлах ёстой гэдэг бас олон улсын энэ стандартаас зөрөөд байна л даа.

Мөн яг мэдээлэл хүсэгч иргэн маань зорилгоо тодорхой болгоод танилцуулаад мэдээллийн эзний зөвшөөрлийг авна гэдэг бол үндсэндээ их ноцтой буюу тухайн мэдээлэл олж авч байгаа субъектэд маань үлэмж хариуцлага хүлээлгэж байна. Иргэн эсвэл ихэнхдээ сэтгүүлч нар байгаа. Энэ маань явж явж нөгөө Үндсэн хуулийн 16-ын 17 дахь зүйлтэй хязгаарлалчих байдалтай ийм заалт болчихоод байна л даа. Тэгээд дээрээс нь ингээд хязгаарлалттай мэдээлэл гээд ангилаад харах юм бол нөгөө Төрийн албаны нууцын тухай хуулийн нэлээд мэдээлэл нь бас ийшээ орчих ийм магадлалтай байгаад байна. Тийм учраас ажлын хэсгээс болон хууль санаачлагчаас хязгаарлалттай мэдээлэл гэдэг нь хасаж болдоггүй юм уу. Ямар үндэслэлээр хязгаарлалттай мэдээлэл гэж оруулав аа гэдэг асуулт асуумаар байна.

### **С.Бямбацогт:** Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. 7 дугаар зүйлтэй холбоотой Нийтийн мэдээллийн ангиллаар асууж байна. Мэдээллээ бид нар ер нь 3 ангилж байгаа. Нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэдэг нэр томъёо анх удаа энэ удаа энэ хуулиар орж ирээгүй. 2018 онд батлагдсан бүртгэлийн багц хуулиар төрд байгаа нийт мэдээллийг суурь мэдээлэл, төрөлжсөн мэдээлэл гэж 2 ангилж байгаа. Яг тэр суурь мэдээлэл нь бол иргэний мэдээлэл, хуулийн этгээдийн мэдээлэл, эд хөрөнгийн мэдээлэл. Энэ бол суурь мэдээлэл. Энэ дээр бид нар яг энэ хязгаарлалттай мэдээлэлд гэж ямар мэдээллүүдийг ангилж өгөх юм. Хаалттай мэдээлэл гэж юуг хэлэх юм. Нээлттэй мэдээлэл гэж юуг хэлэх юм гэж 2018 онд үүнийг ангилж өгсөн. Яг үүнийг улам гүнзгийрүүлж иргэн талдаа илүү.

Жишээ нь хязгаарлалттай мэдээлэл гэж тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр өгч байгаа мэдээллийг л хязгаарлалттай мэдээлэл гэж байгаа юм. Тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр хөрөнгийн мэдээллийг. Тэр эрүүл мэндийн болон тэр хүний хувийн мэдээлэлд хамаарах мэдээллийг зөвхөн тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр өгье. Эрх бүхий албан тушаалтнуудад шууд хандах эрх нь энэ хуулиар нээлттэй байгаа. Ингэснээрээ энэ иргэн талдаа илүү хязгаарлалттай мэдээллийг ашиглахад бусад дамжуулахад илүү тийм мэдэгдлийн системийг ашиглахад иргэн талдаа илүү ашигтай болж байгаа юм. Энэ хязгаарлалттай гэдэг нь Мөнхцэцэг гишүүн ээ, 2018 оноос орсон мэдээлэл байгаа шүү.

Хойшоо бид нар 9 дүгээр зүйл дээр энэ хязгаарлалттай мэдээлэлд яг юу юу хамаарах юм гэдэг нь бол 5 зүйл хамаарч байгаа. 9 дүгээр зүйлээрээ нарийвчилж зохицсон байгаа.

**С.Бямбацогт:** Нямбаатар сайд нэмж хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Мөнхцэцэг гишүүний асуултад нэмээд хариулчихъя. Энэ юу гэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүх мэдээллийг нээлттэй болгож болдоггүй. Өөрөөр хэлбэл прокурорын байгууллагын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээллийг мөрдөн байцаагч буюу мөрдөгч хуульд заасан хүрээ хязгаарын хүрээнд хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагад ил болгож болно. Өөрөөр хэлбэл энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өөрийн хэргээ илрүүлэх тактик, цаашлаад тэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаашаа процессын хуульд заасны дагуу явуулахад бүгдийг нь ил болгосон тохиолдолд саад болно оо гэдэг ийм нэг мэдээлэл байгаа.

Мөн зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотой мэдээллүүд байгаа.

2 дахь зүйл нь болохоор төрийн хяналт шалгалтын явцад энэ мэдээллийг бүгдийг нь ил болголгүйгээр шалгаж дуусаагүй байхад тухайн аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн нэр хүндэд цаашаа халдаад буруу мэдээллүүд явж болзошгүй учраас мөн төрийн хяналт шалгалтын явцад байгаа мэдээллийг бүгдийг нь хязгаартай, эрх бүхий байгууллага албан тушаалтны зөвшөөрлөөр бүгдтэй нь танилцах тэр боломж нь бас нээлттэй болно.

Соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээллийг бас хязгаартай байлгах хэрэгтэй. Жишээлэхэд өнөөдөр яг энэ цаг үед Богд хааны музейд Монгол Улсын хосгүй үнэт бүтээлүүдийн үзэсгэлэн гарч байна. Тодорхой харуул хамгаалалт, хяналт шалгалтын дагуу. Түүнтэй холбоотой мэдээллийг хаана, ямар харуул хамгаалалттайгаар хэдий хугацаанд хамгаалж байгаа талаарх тэр мэдээллүүдийг бас хязгаартай холбогдох байгууллагуудад нь зөвшөөрлийн үндсэн дээр өгнө өө ч гэдэг юм уу. Энэ зүйлүүдийг л хязгаартай мэдээлэл гэж үзэж байгаа. Түүнээс бусад 9 дүгээр зүйлийн 9.2.4, 9.2.5, 9.2.6-д заасан мэдээллүүдийг одоо энэ ажлын хэсгээс боловсруулж орж ирснээр бүгдийг нь нээлттэй мэдээлэл болгоё оо. Хязгаарлалттай мэдээллийн ангилалаас хасъя гэж байгаа. Ийм 3 төрлийн мэдээллийг л хязгаартай мэдээлэл гэж ойлгож байгаа.

Одоо ч гэсэн мөрдөн шалгах ажиллагааны явцад зөвхөн прокурорын зөвшөөрөлтэй мөрдөгч мэдээллээ нийтэд өгдөг яг энэ зүйл хэвээрээ хадгалагдаж байгаа. Бусад хуультайгаа ч гэсэн уялдаж байгаа гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** Санал хураалт явуулъя.

Сая танилцуулчихсан тийм ээ. Саяын танилцуулсан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдээ анхааралтай.

Санал хураалт 62,5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга.

8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнхцэцэг:** 8 дугаар зүйл бол Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу 19-ийн штрих 1-ийн 3-т байгаа улс төрийн намын орлого, түүний зарцуулалт ил тод байна аа гэдэг энэ заалтыг хэрэгжүүлэхэд том дэвшил болсон маш сайн заалт байгаа. Тухайлбал 8.6.15 улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл ил тод байна гэж. Тэгэхээр энэ дээр 1 асуулт байна л даа. Улс төрийн намын гишүүнчлэл гэдэг дээр яг ямар утгаар энэ үг орсон бэ. Тухайлбал гишүүнчлэл гэдэг нь улс төрийн намын гишүүдийн тоог хэлж байна уу эсвэл улс төрийн намын гишүүдийн тухай бүх мэдээлэл нэр ус, овог, ажил гэдэг энэ тодорхой дэлгэрэнгүй мэдээллийг хэлж байна уу. Энэ тал дээр ажлын хэсэг хариулт өгнө үү.

**С.Бямбацогт:** Сайнзориг дарга хариулъя.

**П.Сайнзориг:** Энэ хуулийг боловсруулахдаа бас улс төрийн намын асуудлыг нийтийн мэдээлэл хариуцагч байхаар оруулж ирсэн. Өөрөөр хэлэх юм бол лс төрийн нам нь бас Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдлийн төлөө нийтийн одоо ард иргэд олон нийт нэгдэж эв санаагаа нэгтгэж, үзэл бодлоо нэгтгэж оролцдогийн хувьд бас тодорхой төрлийн мэдээллүүд нь ил тод байх ёстой гэж үзсэн. Үүн дээр бас зарим гадаад улсын туршлагаудыг авч үзсэн. Ер нь гишүүнчлэл буюу хэчнээн гишүүнтэй гэдэг мэдээлэл бол ил тод байх ёстой гэж байгаа юм. Тэгэхээр үүнийг эцсийн байдлаар аль байгууллагаас гарах мэдээлэл нь тодорхойгүй байдаг. Нам, нам өөрсдөө зарладаг. Ийм байгаа учраас бас гишүүнчлэлийн мэдээлэл буюу тооны мэдээ гэсэн үг. Энэ тоо энэ тэрээ бол яг албан ёсоор нээлттэй ил тод тавьдаг ийм байдал руу оръё оо л гэж байгаа юм. Хувийн тэр нэр ус, гишүүнчлэлийн мэдээ бол биш ээ гэсэн үг. Гишүүнчлэлийн тоо гэдэг утгаараа.

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

8 дугаар зүйл. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгая.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9 дэх заалтын “үйл ажиллагааны чиглэлээрх салбарын нэгтгэн боловсруулсан” гэснийг “салбарын үйл ажиллагааны” гэж, өөрчилж, 8.6.20 дахь заалтын “мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн,” гэсний дараа “, гэрээний хэрэгжилт” гэж, 8.7 дахь хэсгийн “энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Улсын дээд шүүх,” гэсний дараа “энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц,” гэж тус тус нэмж, 8.14 дэх хэсгийн “цахим хуудас хариуцсан ажилтан” гэснийг хасч, 8.6.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.6.18 дахь заалт болгох:

“8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт,” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

62,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Төслийн “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “цахим



хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 56 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хууль өнөөдөр Төрийн байгуулалтын эцсийн хэлэлцүүлэг хийгдээд энэ 7 хоногт чуулганаар батлагдана. Түүнтэй нийцүүлэх ёстой шүү. Ажлын хэсэг энэ дээр бас анхаараарай.

Гишүүдээс гаргасан санал алга байна.

9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс бичгээр гаргасан 1 санал байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтын “мэдээлэл авагчийн нэр” гэснийг “мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр” гэж, 9.6.8 дахь заалтын “зөвшөөрлөө цуцлах нөхцөл” гэснийг “зөвшөөрлөө цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчилж, 9.6.4, 9.17.2 дахь заалтын “агуулга,” гэснийг болон 9.2.4, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** 12 дугаар зүйлийн 12.3-т нээлттэй өгөгдлийг төлбөртэй болон төлбөргүй ашиглаж болно оо гэж заасан байна. Ер нь олон улсын жишгээр нээлттэй өгөгдөл нь хэн ч чөлөөтэй нэвтрэн орж ашигладаг тодорхой зорилгоор хэрэглэдэг ашгийн бус зорилгоор ашиглаж дамжуулах, түгээх мөн нэмүү өртөг шингээн дахин ашиглах боломжтой өгөгдлүүд байдаг аа. Дээрээс нь нээлттэй өгөгдлийн байгаа нөхцөлд дахиад энэ дээр инновац хийдэг. Дахин дахин эргэлтэд оруулах боломжтой зохицуулалтууд байдаг. Манай 12.3 энэ заалтыг оруулчхаар маш олон нээлттэй өгөгдлүүд төлбөртэй болоод гараад ирчих ийм сөрөг үр дагавартай байна. Ер нь олон улсын жишгээ дагаад нээлттэй өгөгдлүүд маань үнэ төлбөргүй, угаасаа ашгийн бус зорилгоор ашиглаж байгаа гэдэг утгаараа ингээд явчихвал яасан юм бэ. Ер нь хэрвээ одоо нээлттэй өгөгдлийг төлбөртэй ашиглуулж байгаа бол ашиг олох зорилгоор биш зөвхөн үүнийг түгээхтэй холбоотой зардлыг тооцож төлбөрт шингээж оруулчихмаар байна. Энэ тал дээр ажлын хэсэг болон хууль санаачлагч ямар байр суурьтай байна вэ. Ашгийн бус зорилгоор явж байгаа учраас төлбөргүй л байх ёстой гэдэг утгаар асууж байгаа шүү.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг 3 дугаар микрофон Баасандорж дарга хариулъя.

**Б.Баасандорж:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Засгийн газраас энэ хуулийн төслийг боловсруулахад цахимаар болон танхимаар хэд хэдэн удаа хэлэлцүүлгийг хийсэн юм. Энэ хэлэлцүүлгийг хийхэд төрийн бус байгууллагуудаас яг энэ асуудал хөндөгдөж байсан. Яг энэ 12.3-тай холбоотой асуудлыг. Тэгээд төрийн бус байгууллагуудтай нээлттэй хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр ойлгуулж бас ярилцсан байгаа. Энэ 12.3 дээр заасан нээлттэй өгөгдлийг бол төлбөргүйгээр ашиглаж болох бөгөөд хандахад хялбар байх хуулах эрэмбэлэх бололцоо нөхцөлийг тодорхойлсон байна гээд.

Бид нар төлбөртэйгөөр ямар нөхцөлд ашиглах юм бэ гэхээр Мөнхцэцэг гишүүн ээ, 12.8 дээр байгаа юм. Энэ хуулийн 12.6-д заасан жагсаалтад ороогүй эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө авах хүсэлт гаргасан бол мэдээлэл хариуцагч нээлттэй өгөгдлийг төлбөртэйгөөр нийтэлж болно. Тэгээд 12.8-д заасан төлбөр тооцох аргачлалыг Засгийн газар батална. өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудад нээлттэй өгөгдлийг боловсруулахдаа байнга нийтлэх үүргийг өгч байгаа юм. Тэр хугацаатай. Хугацаанаас нь өмнө магадгүй иргэн хуулийн этгээдүүд хугацаанаас нь өмнө хүсэлт гаргаж болно. Одоо яаралтай ийм ийм хүсэлтээр нээлттэй өгөгдлийг надад өгөөч ээ. Нөгөө төрийн байгууллага нь бид нар энэ сардаа багтаагаад боловсруулалт хийж байна аа гэж хуулиар үүрэг авчихсан байгаа. Тэр хугацаанаас нь өмнө иргэн хуулийн этгээд авах юм бол тодорхой төлбөр төлөөд тэр нээлттэй өгөгдлийг баазаар нь юм уу өргөн хэмжээнд юм уу хэвлэж авах юм уу цахимаар авах юм уу энэ асуудлыг үүгээр төлбөртэйгөөр зохицуулж өгч байгаа юм аа. Түүнээс бусдаар бол тодорхой хугацаа заагаад тэр хугацаанд нээлттэй өгөгдлөө гаргаагүй бол тухайн байгууллагуудад хариуцлагын асуудал энэ дээр яригдаж байгаа юм.

**С.Бямбацогт:** Нямбаатар сайд хариулъя. Хууль санаачлагч.

**Х.Нямбаатар:** Мөнхцэцэг гишүүн ээ, бид нар энэ хуулийн төслийг боловсруулах гээд Засгийн газар дээр Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсгийг нь намайг ахлуулаад бид бас их олон улс орны энэ чиглэлийн энэ төрлийн хууль тогтоомжуудыг харьцуулж судалсан байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт, энэ яг ажлын хэсгээс орж ирж байгаа энэ саналаар нь дэмжээд өгөхийг та бүхнээс хүсье.

3 дугаарт, сая Баасандорж цаг хугацаатай холбоотой асуудлыг маш товчхон тайлбарлалаа. Ер нь дэлхийн дийлэнх улс орнууд нээлттэй мэдээллийг ихэвчлэн нэвтэрч орох эрх нь нээлттэй гагцхүү зарим төрлийн мэдээллүүдийг нөгөө цаашид арилжааны зорилгоор ашиглах гэж байгаа тохиолдолд нь тодорхой төлбөрүүд авдаг ийм жишиг байгаа. Өнөөдөр Архивын ерөнхий газрын дийлэнх мэдээллүүдийг үнэ төлбөргүй гаргаж өгч байгаа. Зарим төрлийн мэдээллүүдийг өөрсдөө төлбөртэй байдлаар хэвлүүлж авахыг хүсэж байгаа. Бэлэг дурсгалын зориулалтаар хадгалж авахыг хүсэж байгаа тохиолдолд төлбөртэй байдлаар бас тэр хатуу биетээр буулгаж өгөх ажлуудыг зохион байгуулж байгаа.

Тэгэхээр амьдрал өөрөө баян учраас Мөнхцэцэг гишүүний хэлж байгаа шиг 100 хувь бүгдийг нь төлбөргүй болгоо гэх юм бол наад маань өөрөө бас амьдралтайгаа уялдахгүй байгаа юм аа. Энэ дээр бид нар үүнийг журам гаргаад

энэ энэ төрлийн мэдээллийг ингэж авах тохиолдолд төлбөртэй, ер нь бол нэвтэрч орох эрх нь нээлттэй. Энэ төрлийн мэдээллүүд байнга үнэгүй байдлаар түгээгдэнэ гэдэг ийм заагийг журмаар цаашид нарийвчилж зохицуулж явахгүй бол бүхэлд нь нийтлэг байдлаар зохицуулалт хийх нь боломжгүй байгаа юм. Тийм учраас Их Хурлын гишүүдийг энэ ажлын хэсгээс гаргасан саналыг зарчмын хувьд дэмжиж өгөхийг хүсэж байна.

**С.Бямбацогт:** Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр нээлттэй өгөгдлийг тухайн төрийн байгууллага гэдэг юм уу мэдээлэл хариуцагч байршуулахаас өмнө авах юм бол төлбөртэй болно гээд. Энэ маань ингэж үзэхээр нөгөө мэдээлэл олж авах гэж байгаа этгээд иргэн орлогоос ялгаатай бас ялгавартай байдал үүсэх гээд байна л даа. Өөрөөр хэлбэл мөнгөтэй хүн эсвэл илүү хөрөнгө мөнгөтэй этгээд мөнгийг нь төлөөд тухайн мэдээллийг цаг хугацааны хувьд түрүүлж авах нь байна шүү дээ. Энэ маань тэр нөгөө орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд ялангуяа ашигт малтмалын гэдэг юм уу иймэрхүү тодорхой салбарууд тодорхой бизнес дээр мэдээллийг түрүүлж төлбөртэй олж авсан нөхдөд давуу байдал үүсгэх вий. Эндээс гол нь айж байна. Тийм учраас болж өгвөл төлбөртэй мэдээлэл өгөгдөл төлбөртэй байна гэдэг уг нь хасчихмаар байгаад байна. Угаасаа энэ чинь ашгийн бус зорилготой нийтэд тавьсан юу гэдгээрээ аль болох л мэдээлэл олж авах байдал хэн нэгэнд ялгавартай байхгүйгээр мөнгөтэй хүн ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** 2 дугаар микрофон. Ойлголтын зөрүү тийм ээ бас байж болно. Ойлголтын зөрүү алга болох ёстой. Чухал асуудал хөндөж байна. 2 дугаар микрофон хариулъя. Сайнзориг дарга.

**П.Сайнзориг:** Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Ер нь нээлттэй өгөгдлийн жагсаалтууд. Ямар ямар биг датанууд байх юм. Энэ нээлттэй өгөгдлийг яг нийтлэг хугацаануудыг буюу түгээх хугацаануудыг Засгийн газар тогтоочих юм. Тэгэхээр энэ хугацааг л үндсэндээ хүлээх болчихоод байгаа байхгүй юу. Зайлшгүй магадгүй тэр аж ахуйн нэгж байгууллага бизнесээ төлөх, шинэ төрлийн бараа бүтээгдэхүүн оруулж ирэх ийм байлаа гэхэд жишээ нь одоо гааль дээрээс хэчнээн хүн даавуу оруулж ирдэг юм бэ гээд энэ оёдлын цех судалгаа авлаа гэхэд бид нийтлээгүй байна аа гээд бас өгөхөд хэцүү. Энэ нийтлэх процессын ард чинь ерөнхийдөө мэдээллийг цуглуулж байгаа тэр зардлууд явж байгаа байхгүй юу. Боловсруулах зардлууд орно. Тэгэхээр энэ өөрөө эргээд ингээд нийтлэг байдлаараа бол үнэ төлбөргүй өгье өө тодорхой цаг хугацаанд түгээх гэж байгаа юмаа. Харин наана нь боловсруулалт хийж авах юмнууд байх юм бол бас тодорхой хэмжээний төлбөр төлөөд авах бололцоог нь иргэн, хуулийн этгээдэд өгье. Энэ нь өөрөө эргээд эдийн засаг, бизнесээ дэмжих л гол зорилго байгаа. Тэгэхээр үүнийг л бас уян хатан байдлаар зохицуулъя гэж байгаа юм.

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна. 18 дээр.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг, 18.14 дэх хэсгийн “цахим хэлбэрээр” гэснийг тус тус хасч, 18.16 дахь хэсгийн “гэрээний загвар,” гэсний дараа “зардал тооцох аргачлал,” гэж нэмж, 18.14, 18.15 дахь хэсгийн “үндсэн систем” гэснийг “үндсэн болон дэмжих систем” гэж, 18.12 дахь хэсгийн “үндсэн системд холбогдсон мэдээллийн сангаас” гэснийг “үндсэн системээр дамжуулан” гэж тус тус өөрчилж, 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Энэ хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем нь нийтийн мэдээллийн системд хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. 22 дээр асуулт байхгүй. Ажлын хэсгээс санал байхгүй.

Цогтбаатар гишүүн бичгээр санал гаргасан байна. Цогтбаатар гишүүн ээ, өөрөө ирж саналаа танилцуулаарай. Тайлбарлаарай.

Өглөө 10 цагт чөлөө аваад явсан, одоо 1 цаг болж байна.

Өглөө ирцэд орчхоод явсан Адьшаа гишүүн хуралдаандаа ирье ээ. Сууж байгаа гишүүд нь ингээд ажлаа хийгээд байдаг. Гишүүд ирцдээ орчхоод картаа хийххээд ирцдээ орсон одоо боллоо гээд гадуур хувийнхаа ажил байдаг юм уу юу хийдэг юм. Яваад байж болохгүй шүү дээ. Саранчимэг гишүүн бас. Цогтбаатар

гишүүн чөлөө авсан, чөлөөний хугацаа дууссан. Саранчимэг гишүүн өглөө картаа хийчихээд л гараад алга болсон. Хаачсан, хаагуур явж байгааг мэдэхгүй. Амарсайхан гишүүн бас Шадар сайд ажилтай байж болно оо гэхдээ хуралдаанд оролцох ёстой. Байнгын хорооныхоо хуралдаа. Амартүвшин гишүүн маань сууж байсан, бас хааччихав аа, хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Мөнхбаатар гишүүн бас өглөө ирцэд орсон, картаа сугалаад явсан байна. Раднаасэд гишүүн бас өглөө байж байсан, нэлээн байсан, саяхан гараад явсан байна. Хуралдаанд урьж байна. Сандаг-Очир гишүүн ажлын хэсэг чөлөө авсан байгаа. Ажлын хэсэг хуралдаж байгаа. Ийм байна шүү гэдгийг хэлье.

Тасалсан гишүүдээ дахиж цоллоно оо, одоо. Хууль зүйн байнгын хорооноос тасалсан гишүүн байхгүй байгаа. Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Бат-Амгалан гишүүн, Ганхуяг гишүүн, Ганибал гишүүн, Доржханд гишүүд тасалсан байна. Хуралдаандаа ирнэ ээ. Хэрэв үнэхээр өвчтэй байгаад тэр ковид туссан байдаг юм бол бичгээ ирүүлээрэй. Тэгэх юм бол тасалсныг чинь залруулж болно. Сууж байгаа хүмүүс нь ингээд хуралдаад ажлаа хийгээд байдаг тийм үү, суухгүй ирцэд орчхоод нэг хэсэг нь алга болчихдог. Нэг хэсэг нь тасалчхаад өвчтэй гээд алга болчихдог байж болохгүй шүү дээ. Бүгдээрээ л ажил төрөл алба, амины зөндөө л ажил байдаг байх. Албан ажлаа л хийх ёстой байх.

Цогтбаатар гишүүн санал гаргасан байна. 22.1 дээр.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн 22.1-д заасан “нийтийн мэдээллийн” гэснийг “үндсэн” гэж өөрчлөх. Тайлбарлах хүн байхгүй учраас. Болор-Эрдэнэ тайлбарлах уу. Ажлын хэсэг. 4 дүгээр микрофон.

**Б.Болор-Эрдэнэ:** Энэ дээр тайлбар өгье. 22.1 дээр нийтийн мэдээллийн системээр илгээсэн хүлээн авсан мэдээллийг илгээсэн хүлээн авсан хугацаа илгээгч хүлээн авагч мэдээллийн агуулгыг илэрхийлэн дахин давтагдашгүй утга болон бусад мэдээллийг бүртгэлийн системээр бүртгэнэ гэж байгаа. Тэгэхээр нийтийн мэдээллийн системд маань дэмжих систем гэх мэтчилэн маш олон системүүд орж байгаа учраас бид нар энэ бүх систем дээр явж байгаа мэдээллүүдийг бүртгэхэд маш их асуудалтай болчихож байгаа. Тэгэхээр үүнийг зөвхөн үндсэн системээр илгээсэн болгож өөрчлөх ийм шаардлагатай байгаа.

**С.Бямбацогт:** Санал хураалт явуулъя. Цогтбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Цогтбаатар гишүүн ээ, санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 24 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасч, 24.4 дэх хэсгийн “нэгдсэн системээс” гэснийг “нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгийн 1 санал байна. Санал хураалт явуулъя.

Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга.

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна. 27 дээр.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ санал дэмжигдсэнгүй. Сүхбаатар гишүүн, ажлын хэсгийн гишүүн. Горимын санал.

**Ж.Сүхбаатар:** Миний энэ төхөөрөмж ажилласангүй. Дахиад санал хураалгаж өгөөч. Одооны санал хураалтыг хүчингүй болгож өгөөч.

**С.Бямбацогт:** Сүхбаатар гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүй болгоё.

62,5 хувиар горимын санал дэмжигдлээ.

Түрүүн саналын томъёоллыг уншсан. Ажлын хэсгийн саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “албан харилцаанд” гэснийг “хуульд заасан чиг үүргийн хүрээнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 32 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “33.1.15-д” гэснийг “33.1.4, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16, 33.1.18-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Төслийн 34 дүгээр зүйлийн 34.5.3 дахь заалтын “түүхчилсэн бичлэг /лог/ үүсгэх” гэснийг “үйлдлийн бүртгэл үүсгэх” гэж өөрчилж, 34.5.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Хуулийн төслийн 35.1.4 дээр мэдээллийн сангийн хамгаалалт аюулгүй байдлыг хариуцна гэдэг ийм заалт байна. Ер нь энэ хууль

маань бүхэлдээ Монгол Улсын цахим аюулгүй байдлыг хангах, үүнийг хамгаалах зохицуулалт маань зөвхөн энэ заалтаар харагдаад байх шиг байх юм. Засгийн газрын цахим асуудал хариуцсан шинэ яам маань үүнийг хариуцах уу. Үндэсний дата төв гээд яг энэ хууль дээр бол цахим аюулгүй байдал, цахим халдлагаас хамгаалах зохицуулалт маань аягүй бүдэг харагдаад зөвхөн 35.1.4 дээр ийм заалт орж ирсэн байна. Тэгэхээр бүхэлдээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг том чиглэл болсон цахим аюулгүй байдлын асуудлыг яаж хамгаалах гээд байгаа юм бэ. Зөвхөн энэ заалт бол бид нарт харагдаад байна. Хууль санаачлагчаас асууж байгаа юм.

**С.Бямбацогт:** Учрал гишүүн. Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Дараа нь ажлын хэсгээс бэлдэж байгаарай.

**Н.Учрал:** Нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбогдуулаад энэ хуульд үндсэн систем, дэмжих систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем гээд ойлголтууд явж байгаа. Үндсэн систем гэдэг бол түрүүн хэлсэн тэр хур системтэйгээ төрийн үйлчилгээний системүүдийг уях зорилгоор тал бүрд мэдээлэл солилцдоггүй өнгөрсөн хугацааны алдаагаа эргэж харах үүднээс энэ үндсэн системийг хуульчил өгч байгаа.

Дэмжих систем дотор бол түрүүн хэлсэн нөгөө танилт нэвтрэлтийн систем дагах системүүд нь мөн нөгөө төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу одоо хэрэгжиж байгаа и-монголиа үүнд харьяалагдаад явна. Бүхэлд нь бол энэ дэд бүтцийн талаар мэдээлэл хариуцагч хүлээлгэх үүрэг дотор энэ аюулгүй байдлыг нь хариуцуулах хадгалалт хамгаалалтын асуудлыг нь оруулж өгсөн. Тэгэхдээ үүнээс гадна Кибер аюулгүй байдлын хууль бас Засгийн газраас яг энэ хуулиудтай хамт өргөн мэдүүлсэн. Тэгэхээр 1 ажлын хэсэг ажиллаж байгаа. Дараа 7 хоногт Кибер аюулгүй байдлын хуулийг гадаад бодлого аюулгүй байдлын байнгын хороотой хамтарч хэлэлцэнэ. Тэр үеэр аюулгүй байдлын тогтолцоогоо ажлын хэсэг дээр бид нэлээд ярилцаад энэ үндэсний сер төв байгуулах, төрийн нэгдсэн төв байгуулах гээд тогтолцооны хувьд бас энэ хуульд тусгаж оруулж ирж байгаа. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөл ажиллах тэгээд халдлагатхй тэмцэх үйл ажиллагаанууд нь маш тодорхой болж байгаа. Тэгэхээр Кибер аюулгүй байдлын бие даасан хуулиар бас зохицуулж байгаа. Тэр хуулийн үеэр хэлэлцүүлгийн үеэр та бүхэн саналаа хэлээд явж болно оо.

**С.Бямбацогт:** Ерөнхийдөө болчихлоо, хариулт. Тийм ээ. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хууль явж байгаа. Энэ дээр бид нар Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам гэсэн 2 яам байгуулагдаж байгаа. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудал үндсэн чиг үүргийн хүрээнд энэ цахим харилцаа холбоо, сансар мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бодлого зохицуулалт, цахим засаглал салбарын хөгжлийн мэдээллийн технологийг дэмжих асуудал, радио давтамжийн бодлого, бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого зохицуулалт, нийтийн мэдээллийн дэд бүтцийн асуудал, харилцаа холбоо, мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлэх асуудал гэсэн Засгийн газар ингэж өргөн барьсан байгаа. Ажлын хэсэг бас ярьж байгаад. Кибер аюулгүй байдлын бодлого, зохицуулалт, мөн цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого зохицуулалт гээд. Өөрөөр хэлэх юм бол бид нар хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой асуудлыг энэ сайдад хариуцуулах дээрээс нь кибер аюулгүй байдлын бодлого гээд сая Нийтийн мэдээллийн хуульд энэ үндсэн чиг үүргийг бас энэ сайдад хариуцуулахаар зохицуулж байгаа. Нэмэлт мэдээлэл өгчихье.



Ингээд санал хураалт явуулъя. Сая томьёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр санал алга.

36 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр санал алга байна.

Хуулийн төслийн 37 дугаар зүйлтэй холбоотой асуулт байна уу. Энх-Амгалан гишүүн, дараа нь Ундрам гишүүн.

**Б.Энх-Амгалан:** Энэ хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага гэдэг ийм заалт байгаа юм л даа. Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 17-д заасан заалт байгаа юм. Тэр болон түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй мэдээллийн асуудлаар бол мэдээлэл хүлээж авч болно оо гэж. Нууцад хамаарах ийм асуудлаар Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар нийгмийн хэв журмыг хангах зорилгоор хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хуулиар хамгаалсан юм байгаа юм. Сүүлийн үед Монголын үнэт өв болсон архивын баримт, тэгээд ховор ном зохиол, дээр нь нөгөө археологийн олдвор, оюуны үнэт зүйл, нөгөө ардын аман зохиол гээд баахан юмнууд чинь гадагшаа гараад байдаг. Тэрийг зарчихсан гэнэ ээ, өгчихсөн гэнэ ээ, хувилаад өгчихсөн гэнэ ээ гээд л. Дуурилаг нарснаас олдсон баахан олдворыг Солонгос руу аваад явчихсан гэнэ ээ. Ингээд л нэг баахан юм. Энэ хэрэгсүүрийг ухаад ингээд гараад явчхаж гэнэ ээ одоо ингэж гэнэ ээ гээд. Үүнээс чинь болоод зарим улс түүхээ урагшлуулах гээд энэ чинь манайд байсан юм аа. Чингис хааны чинь 7 үед Монгол хүн байгаагүй юм аа энэ тэр гээд юм гаргаад яваад байдаг. Энэ бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой ийм асуудал байна л даа. Тэгэхээр энэ мэдээллийн аюулгүй байдлаа, нийтийн мэдээллийнхээ аюулгүй байдлыг нийтийн өмчийнхөө энэ аюулгүй байдал дээр яаж хандаж байгаа юм. Зөрчсөн албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх юм. Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн хуулиараа хариуцлага хүлээгээд Зөрчлийн хуулиараа торгоод өнгөрөх юм уу. Эрүүгийн хуулийн заалттай байх ёстой юм уу. Энэ тал дээр хууль санаачлагч нар ямар ажил төлөвлөж байгаа юм үүнийг надад хэлж өгөөч.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Н.Учрал:** Энэ хууль дээр Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль дагалдаж байгаа. Тэгэхээр түрүүн хязгаарлалттай мэдээлэл дотор хосгүй үнэт өвийн асуудал бол хязгаарлалттай мэдээлэлд орсон. Тэгэхээр гишүүддээ бас хэлэхэд хязгаарлалттай мэдээлэл гэдэг бол яг хаалттай шиг огт хориглосон зүйл байхгүй. Мэдээллийг ашиглах бол тухайн мэдээллийн эзний зөвшөөрлөөр ашиглаж болно гэж байгаа юм. Тэгэхээр энэ нийтийн мэдээллийн хууль тогтоомжийг зөрчих буюу албаны нууцаас бусад хязгаарлалттай мэдээлэл гэж түрүүн хэлсэн нөгөө бизнесийн асуудлыг нь хасаад ингээд 3 мэдээлэл байгаа. Тэр хязгаарлалттай мэдээллийг хууль бусаар ашигласан, задруулсан бол гэмт хэргийн шинжгүй бол энэ Зөрчлийн хуулиар зохицуулна. Гэмт шинжтэй бол түүнийг Эрүүгийн процессынхоо хуулиар зохицуулаад явна. Энэ хууль тогтоомжийн гол амин сүнс нь бол тэр мэдээлэл хариуцагч тал буюу цуглуулж боловсруулж ашиглах мэдээллийг цуглуулж байгаа тал бол өөрөө үүрэг

хариуцлагаа хүлээж байгаа шүү дээ. Тэгэхээр бол 1 онцлогтой. Гэмт хэргийн шинжгүй бол энэ Зөрчлийнхөө хуулиар торгоод явж байгаа. Зүгээр гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хуулиар зохицуулна.

2-т, нээлттэй 67 мэдээллийг нээлттэй болго гэдэг бол мэдээлэл хариуцагч талд бас хариуцлага оногдуулж байгаа. Энэ хууль гарснаараа тэр ашигт малтмалын лицензээ, тэр онцгой комиссын дүгнэлтээ ил болгох үүрэг төрийн байгууллагуудад оногдоно. Хэрвээ түүнийг нээлттэй байршуулаагүй тэр зар самбар дээр, вэб хуудсан дээр байршуулаагүй бол тухайн хуулийн этгээдийг бас Зөрчлийн хуулиар торгох санкц нь бас энд сууж байгаа.

**С.Бямбацогт:** Ундрам гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрам:** Би яг саяынхтай холбоотой 1 кейс дээр тодорхой хариулт авмаар байгаа юм. Сүүлийн 1 жил гаруй хугацаанд Монголын тэргүүний түүхчид 1 асуудлыг дэвшүүлээд байгаа байхгүй юу. Монгол Улсын 1725-1911 оны 200 орчим жилийн түүх хамаарах Хүрээ сайдын хөмрөг гэж байгаа. Энэ бол архив гэсэн үг шүү дээ. Хүрээ сайдын хөмрөгийг Хятадын байгууллагад зарчихсан байна. Тэр нь хэвлэгдээд ном болоод гарахдаа АНУ-ын Конгрессын номын санд Хятадын орон нутгийн түүх гэсэн ангилал доор хүрээг Хятадын зүгээр нэг хошуу гэсэн байдлаар гуйвуулан буулгаад дэлхийд сурталчилж байгаа энэ асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголын 1725-1911 он хүртэлх энэ түүх сан хөмрөг чинь нээлттэй мэдээлэл юм уу хаалттай мэдээлэл юм уу. Үүнийг зүгээр нээлттэйгээр дуртай нь аваад энд тэнд хэвлүүлээд явж болох юм уу. Яг аль хуулиар зохицуулагдах юм бэ. Энэ хуулийн 7.6-д бол нөгөө хаалттай мэдээлэл гэдэг нь байна шүү дээ. Яг үүндээ хамрагдах юм уу эсвэл нээлттэй юм уу. нээлттэй мэдээлэл бол энэ хуулиар хариуцлага хүлээгдэх ёстой.

Хаалттай мэдээлэл бол өөр хуулиар хариуцлага хүлээгдэх нь байна шүү дээ. Яг энэ дээр энэ Хууль зүйн сайд байгаа дээр тодорхой хариулт авмаар байна. Манай их сургуулийн багш нар надад жил гаруй энэ асуудлыг тавьж байгаа.

**С.Бямбацогт:** Эрдэнэсийн сангийн тухай хууль байгаа. Эрдэнэсийн сангийн тухай хуулиар бид нар үндсэндээ Монгол Улсын эрдэнэсийн санд бүртгэгдсэн эд зүйлс, оюуны болон биет бус өв соёл бүгдийг бүртгээд энэ хуулиараа хамгаалаад дээрээс нь энэ бүртгэгдсэн зүйлсийг нээлттэй байлгах ийм хуультай.

Түүний хөдөлгөөн нь бол яах вэ нууц байх тийм үү. Хуультай. Энэ хуулийн шинэчилсэн найруулга хийгдэж байгаа. Энэ хүрээндээ явагдах байх аа. Үүнээс өөр Нийтийн мэдээллийн тухай хуультай яаж холбогдох юм.

Нямбаатар сайд. Архивын материал гэж байгаа юм байна. Эрдэнэсийн сан биш.

**Х.Нямбаатар:** Энэ хууль батлагдсаны дараа бид нарын хийх хамгийн том ажил бол Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг шинэчилж гаргаж ирэх шаардлагатай байгаа.

2 дугаарт, бид нар нээлттэй юуны жагсаалтад 56 нэр төрлийн жагсаалтад саяын Ундрам гишүүний дурдсан түүхийн нэн чухал тэр олдвор, бичгийг нээлттэй

ангилалтад оруулаагүй байгаа. Энэ шинжлэх ухааны зорилгоор ашиглах тэр боломжуудыг одоо ч гэсэн холбогдох хууль тогтоомжуудад бий болгож өгсөн. Сая тэр Чин гүрэний үед хамаарах архивын ховор баримт бичгийг гадаад улсад зарсантай холбоотой асуудал дээр эрүүгийн хэрэг үүсгэгдээд шалгагдаж байгаа. Холбогдох албан тушаалтныг өнгөрсөн 7 хоногт яллагдагчаар татсан. Эрүүгийн хэрэг үүсгээд шалгаж байгаа. Яг хэргийн талаар би дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Өнгөрсөн 7 хоногийн 4 дэх өдөр яг энэ хэрэг дээр яллагдагчаар татсан байгаа.

Зүгээр энэ манай Байнгын хорооны гишүүд мэдээлэл авъя гэвэл бид нар ямар ямар зүйл дээр соёлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн бэ гэдэг дээр тодорхой танилцуулгуудыг хийж болно. 1 дүгээрт.

2 дугаарт, сая Энх-амгалан гишүүн ч бас хэллээ. Энэ соёлын өвийн эсрэг гэмт хэргийн ял шийтгэлийг чангатгах тал дээр та хэд Засгийн газар ямар бодлого барьж байгаа вэ гээд. Энэ 12 сардаа багтаж оруулж ирэх гээд байна. Манай яам нэлээн хэдэн хуулийн төслүүдийг ондоо багтаж өргөн барих юм. Түүний нэг нь Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга. Энэ Сангийн яам нөгөө өргөн мэдүүлэх зөвшөөрөл өгчих юм бол бид нар эхний ээлжид Зөрчлийн тухай хуулийг шинэчлэн найруулга байдлаар өргөн барина.

Дараагийн ээлжид бид нар Эрүүгийн хуулийн тодорхой төрлийн гэмт хэргүүдтэй төрийн ял шийтгэлийн бодлогыг чангатгаж байгаа тэр нэмэлт, өөрчлөлтөө та бүхэнд бас өргөн барихаар бэлдэж байгаа. Үүн дотор хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийлэл, бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт оногдуулж байгаа ч шийтгэлийн бодлогоо чангатгах, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт оногдуулж байгаа ял шийтгэлийн бодлогоо чангатгах гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчиж байгаа гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын бодлогоо чангатгах, эрүүдэн шүүх гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаагүй болгохоор бас оруулж ирж байгаа. Яагаад гэвэл олон улсын Ромын дүрэмд хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн ангилалтад эрүүдэн шүүх гэмт хэрэг хамаардаг. Ромын дүрэмд нэгдэж орсон улс орнууд тухайн төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байхаар үүрэг хүлээсэн конвенцын гишүүн орны хувьд. Тэр утгаараа бид нар нэлээд олон төрлийн энэ яг тодорхой төрлийн ял шийтгэлийн бодлогоо чангатгаж байгаа ийм зүйлүүдийг Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирэхээр төлөвлөөд ажиллаж байна. Одоо яам дээр одоо ч гэсэн ажлын хэсэг байнгын ажиллагаатай байгаа. Энэ дотор соёлын өвийн эсрэг гэмт хэргийн ял шийтгэлийн бодлогыг чангатгах ажил орсон гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Саналын томьёоллыг уншаад танилцуулчихсан тийм ээ. Байхгүй бил үү. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Ажлын хэсгээс санал гараагүй байна.

38 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна.

Төслийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “2022 оны 6 дугаар сарын 01-ний өдөр” гэснийг “2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө нийтийн мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд энэ хуульд заасан шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга.

Хуулийн төслийн 39 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

Ажлын хэсгээс бэлдсэн 2 зарчмын зөрүүтэй санал байна.

Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Одоо хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. 4 санал байна.

Найруулгын санал.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “мэдээллийн системийн тусламжтайгаар” гэснийг “мэдээллийн системийг ашиглан” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын “харилцах утас” гэснийг “харилцах утасны дугаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.10 дахь заалтын “зохион явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 8.4.14 дэх заалтын “олон улсын байгууллагаас авах зээл” гэснийг “олон улсын байгууллагаас авсан зээл” гэж, 9.15 дахь хэсгийн “баталгаа” гэснийг “баталгаажуулалт” гэж, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн “үйл ажиллагааны болон” гэснийг “үйл ажиллагаа,” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.5 дахь заалтын “нэвтрэлт хийгдсэн” гэснийг “нэвтэрсэн” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “мэдээлэл хариуцагч,” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийн “ил тод, нээлттэй” гэсний өмнө “байнга” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “соёлын хосгүй” гэсний дараа “үнэт” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “тухайлсан” гэж тус тус нэмэх.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.14 дэх заалтыг доор дурдсанаар 8.6.14, 8.6.15 дахь заалт болгох:

“8.6.14.шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;

8.6.15.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг, гишүүдээс санал гараагүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн нэрээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс 1 саналтай байна.

Төслийн 1, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.9-д заасныг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “мөрдөж болно” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “тоон гарын үсгээр” гэснийг “цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2” болгож өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал гараагүй байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс санал гараагүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс санал гараагүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс санал гараагүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна.

Ажлын хэсгээс 1 саналтай байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “15.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хязгаарлалттай мэдээллийг” гэсний өмнө “Албаны нууцаас бусад” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.



Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Цогтбаатар гишүүн хуралдаа хүрэлцэн ирж. Баярлалаа. Эхлэхэд нь ирдэг юм байна. Төгсөхөд нь ирдэг юм байна аа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс санал гараагүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан санал байхгүй байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт байна уу. Алга байна. Ажлын хэсэг болон гишүүдээс бичгээр гаргасан санал байна уу. Алга байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Учрал гишүүн танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан ингээд 2 том хуулийн төслийг хэлэлцээд нэлээн том ажлын ард гарч байна. Нийтийн мэдээллийн тухай хууль, Хувь хүний нууцыг хамгаалах тухай хууль бол маш чухал хуулиуд аа.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Алтанхуяг гишүүн, Мөнхцэцэг гишүүн, Энх-Амгалан гишүүн, Цогтбаатар гишүүн, Ундрам гишүүн, Сүхбаатар гишүүн, Нямбаатар гишүүн, Батшугар гишүүн, Сэргэлэн гишүүн, Учрал гишүүн нартаа баярлалаа.

Ажлын амжилт хүсье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ